

Газарзүй, Геоэкологийн хүрээлэн,
Цөлжилтийн судалгааны салбар

ЦӨЛЖИЛТ БА



ДОРРОЙГОМ ГАЗРЫЙН

Ерөнхий боловсролын сургуулийн дунд,
ахлах ангийн сурагчдад зориулсан танин
мэдэхүйн товхимол



АГУУЛГА

01

Цөлжилт, газрын доройтол гэж юу вэ?

02

Цөлжилтөд нөлөөлөх хүчин зүйлс

03


Цөлжилтийн үр дагавар

04

Дүгнэлт

ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРЙТОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Нэгдсэн Үндэстний Байгууллагын тодорхойлолт (1994)-оор цөлжилтөөс үүдэн хөрсний бүтэц алдагдаж, агууламжид өөрчлөлт орсноор хөрсний үржил шим алдагдах үйл явц бөгөөд үр дүнд нь хөдөө аж ахуйн бүтээмж багасаж, байгалийн олон зүйлийн ургамал устаж үгүй болох аюулд хүрдэг байна. Мөн цөлжилт нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр хуурай ба хагас хуурай газар нутгийн биологийн бүтээмж буурах үйл явц юм. Энэ нь цөл тэлэх ойлголтоос өөр ойлголт юм. Хуурай, хагас хуурай, хагас чийглэг бүсийн хөрс, газар нутаг, биологийн бүтээмжийн доройтол нь хэд хэдэн хүчин зүйлээс үүддэг. Жишээ нь, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа гэх мэт хүчин зүйлс нөлөөлдөг байна.



ЦӨЛЖИЛТӨД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Цөлжилтөд хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд, байгалийн хүчин зүйл (хур тунадас хэт их орох эсвэл ган болох) зарим тохиолдолд хүний хүчин зүйлээс (ХАА, үйлдвэрлэл гэх мэт) шууд хамаардаг байна.

Газрын доройтол нь газар ашиглалтын хэлбэрүүд тухайн газрын онцлогт тохироогүй тохиолдолд үүсдэг гэх тодорхойлолтыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага 1976 онд гаргасан байна. Газар ашиглалтыг ерөнхийд нь 4 төрөлд хувааж авч үзэж болно: (1) Тариалангийн зориулалтаар (2) Бэлчээрийн зориулалтаар, (3) Ойн зориулалтаар (4) бусад зориулалтаар ашигладаг байна.

Цөлжилт нь нийгэм, эдийн засгийн, улс төрийн, байгалийн хүчин зүйлсийн харилцан үйлчлэлээс үүдэн бий болдог ба энэхүү хүчин зүйлс нь бүс нутаг бүрд ялгаатай байдаг байна.

Газрын нөөцийн тогтвортой бус ашиглалтын хэлбэрийг дэмжсэн бодлого, дэд бүтцийн бүтээн байгуулалт явагдаагүй зэрэг нь газрын доройтолд ихээхэн сөргөөр нөлөөлдөг. Хөдөө аж ахуйн салбар хэрхэн зохицуулалт хийж буйгаас шалтгаалан цөлжилт, газрын доройтолд эергээр болон сөргөөр нөлөөлдөг. Бэлчээрлэлтэд илүү тохирсон газар нутагт суурьшмал газар тариалан эрхлэхийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх нь цөлжилтийг эрчимжүүлдэг. Даяарших үйл явц нь цөлжилтийг бий болгох нөхцөл болохоос гадна сэргийлэхэд мөн тусалдаг. Зарим тохиолдолд зах зээлийн либералчлал, эдийн засгийн шинэчлэл, экспортод түшиглэсэн үйлдвэрлэл нь цөлжилтийг эрчимжүүлдэг. Монгол улсын хувьд малын түүхий эд болох арьс шир, сүү, махны нэгжийн үнэ ханш хөдөөд маш бага, хотод дамлан зарагдахдаа хэд дахин өсдөг үзэгдэл ажиглагддаг. Энэ нь малчид, тэр дундаа говийн бүсийн малчид малаа ихээр өсгөхөд хүргэдэг бөгөөд говийн малчдын хувьд 1000 шахам тоо толгой малтай 4-5 ам бүлтэй өрх амьжиргаагаа залгуулахад хүндхэн нөхцөл байдалтай байна. Түүнчлэн, малын зарим нэг түүхий эд болох ноолуурын ханш өндөр байгаагаас говийн малчид ямааг ихээр өсгөхөөс өөр аргагүй хүрч байгаа нь цөлжилтийг эрчимжүүлэх нэг шалтгаан болж байна. Үүнээс үзэхэд зах зээлийн либералчлал, экспортод түшиглэсэн үйлдвэрлэл цөлжилтөд нөлөөлж буй нь тодорхой юм.



01

Бэлчээрийн даац хэтрэлт

- Бэлчээрийн даац хэтрэх нь
- Бэлчээрийн газрыг сэлгэхгүй ашиглах,
- Бэлчээрийн даацаас хэтэрсэн малын тоо, нягтшил,
- Цаг уур, хөрсний шинж чанар тохиромжгүй бэлчээрийг ашиглах, Малын хөлд талхлагдах, үерийн урсцаар бэлчээр сүйтгэгдэх, зэрэг хүчин зүйлсээс хамаардаг.

02

Ойн доройтол

- Ой мод нь нүүрстөрөгчийг шингээх үүрэгтэй.
- Ойн доройтол нь нүүрсхүчлийн давхар ислийг агаарт алдсанаар хүлэмжийн хийн нөлөөллийг ихэсгэдэг.

03

Зохисгүй тариалан эрхлэлт

- Тариалангийн талбайг шалааж, цэвэрлэх нь хөрс элэгдэх нөхцөлд хүргэдэг
- Газрын хэт их хагалах, услах зэрэг нь хөрсний эрдэс бодисын агууламжийг бууруулдаг.

Усжуулалт бүхий талбайн хувьд

- Хэт их усалгаанаас шалтгаалсан хөрсний элэгдэл;
- Давсжилт – Хатуулаг өндөртэй гүний усыг усжуулалтад ашигласнаас үүдэн хөрсөнд давсжилт бүхий давхарга үүсэх;
- Газрын гүний усны хэт их ашиглалт;
- Тариалангийн газрын тасралтгүй ашигласнаар үржил шимтэй хөрс алдагддаг байна.

04

Байгалийн нөөцийн ашиглалт

- Хотжилт ихсэх тусам байгалийн нөөцийн эрэлт, хэрэгцээ болон ашиглалт ихсэж, цөлжилтөд өртөмтгий эмзэг, хэврэг газрын талбай ихэсдэг. Жишээ нь, Монгол орны говийн бүсэд заган ой нь ихээр доройтсон байдаг бөгөөд байгалийн нөөцийг зохисгүй ашигласнаас үүдэн хөрс салхиар элэгдэх үйл явц эрчимжих үндэслэл болдог. Гэвч, говийн бүсийн алслагдсан сумдын иргэд, малчдад бусад дулааны эх үүсвэр хомс тул загийг түлэх нь амьд үлдэх гарцаагүй нэг арга зам болж байгаа юм. Тиймээс орон нутгийн удирдлагаас тодорхой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

05

Уур амьсгалын өөрчлөлт

- Уур амьсгалын өөрчлөлт нь температур, хур тунадас, нарны ***, салхины чиглэл зэргийг орон зайн болон цаг хугацааны хувьд зүй тогтолд нь өөрчлөлт оруулснаар цөлжилт эрчимжих үндэс болдог.

06

Байгалийн гамшиг

- Үер, ган, хөрсний гулгалт зэргээс шалтгаалан хөрс усаар элэгдэх, үржил шимт хөрсний давхарга шилжих, хөрс усаар элэгдэх зэрэг үзэгдэл ажиглагдах бөгөөд энэ нь цөлжилтийн эхний шат юм.

07

Салхиар элэгдэх үйл явц

- Элсний нүүдлээс шалтгаалж элсээр бүрхэгдсэн талбай ихсэх тусам хөрсний үржил шим алдагддаг бөгөөд цөлжилтөд өртөмхий байдал нь нэмэгддэг.

Цөлжилтийн үр дагавар

Цөлжилтийн үр дагавар нь урт хугацааны турш аажмаар явагддаг бөгөөд гэнэтийн аюулт үзэгдэл биш хэдий ч үр дагавар нь маш ноцтой илэрдэг байна.

Хөрс элдэгдэж, эвдэрснээр борооны усыг шингээх чадвар нь алдагддаг. Ингэснээр гүний усны хэмжээ мөн багасдаг.

Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл:

1. Ургамлан бүрхүүлийн доройтол
2. Хөрсний үржил шим муудах
3. Хөрсний элэгдэл
4. Байгалийн гамшигт үзэгдэл өртөмтгий болох
5. Газрын доройтол
6. Усны бохирдол
7. Биологийн олон янз байдал алдагдах, ховор амьтан ургамлууд устаж, үгүй болох

Эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

1. Үер, хөрсний гулгалт, ган зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ихсэх
2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд алдагдал учрах
3. Ядуурал ихсэх
4. Эдийн засгийн ерөнхий үзүүлэлт буурах



Нийгэмд үзүүлэх нөлөөлөл:

1. Өлсгөлөн, ядуурал нэмэгдэх,
2. Нийгмийн зөрчил, тэмцэл гарах
3. Шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, жишээ нь бэлчээрийн даац хэтэрснээс шалтгаалан өөр сумд руу нүүх зэрэг нь байгаль орчны нөхцөл байдлаас шалтгаалан дүрвэж буй хэлбэр юм.
4. Хүнсний аюулгүй байдалд аюул учрах

Улс төрийн нөлөөлөл:

1. Цөлжилт, газрын доройтлоос үүдэлтэй хохирол нь улс төрийн тогтворгүй байдалд хүргэдэг.



ДҮГНЭЛТ

Цөлжилтөөс урьдчилан сэргийлэхийн тулд байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжсэн менежмент, бодлогын арга барил шаардлагатай. Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг тэглэхийн тулд бүс нутгийн болон дэлхийн түвшинд бодлого, менежментийн томоохон өөрчлөлт, шинэчлэлийг хийх шаардлагатай байна.

1. Цөлжилт нь хүн төрөлхтөнд тулгарч буй томоохон сорилтуудын нэг бөгөөд хүн төрөлхтний суурь хэрэгцээг хангахад ихээхэн саад учруулж байна.

2. Цөлжилт нь хуурай газрын экосистемд илрэх хөрсний үржил шим алдагдах үйл явц бөгөөд биологийн бүтээмж, түүнчлэн сая сая хүний амьжиргаанд сөргөөр нөлөөлдөг. Цөлжилт нь хүний болон байгалийн хүчин зүйлсээс үүдэлтэй.

3. Хуурай газрын 10-20% нь хэдийн доройтолд өртсөн бөгөөд цөлжилт нь дэлхийн хамгийн эмзэг бүлгийн хүн амд ихээхэн дарамт үзүүлж байна. Цөлжилт болон түүний хүн төрөлхтөнд нөлөөлөх нөлөөллийг олон хувилбараар судалсан судалгаанууд олон ба цаашид цөлжилт улам бүр эрчимжих хандлага ажиглагдаж байна.



4. Урьдчилан сэргийлэх нь цөлжилттэй тэмцэх хамгийн үр дүнтэй арга юм, учир нь цөлжсөн газар нутгийг нөхөн сэргээх нь өртөг өндөртэй бөгөөд үр дүн нь хязгаарлагдмал байдаг. Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх нь бүс нутгийн хэмжээнд төдийгүй дэлхийн хэмжээнд үр дүнтэй арга юм. Цаашлаад биологийн олон янз байдлын алдагдал, дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чухал нөлөөтэй.

5. Цөлжилттэй үр дүнтэй тэмцэх нь ядуурлыг бууруулах, Мянганы хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд өндөр ач холбогдолтой.



ШУА

Газарзүй, Геоэкологийн хүрээлэн,
Цөлжилтийн судалгааны салбар